

**АЛТАЙ ЗАМ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо:	2026.04.03	
Эхэлсэн цаг:	15:00	
Дууссан цаг	16:00	
Хаана:	Улаанбаатар хот. ХУД 23-р хороо, “Алтайн Зам” ХК – ийн хурлын танхим	
Хурлын төрөл:	☒ Ээлжит хурал	☐ Ээлжит бус хурал
Дугаар:		

Хурлын ирц

1	М.Нямдаваа	ТУЗ-ийн дарга	☒ ирсэн	☐ ирээгүй
2	С.Балжинням	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
3	Ц.Ганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
4	Г.Сономжамц	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
5	Б.Бат-Ирээдүй	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
6	С.Баянчулуун	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
7	С.Баянмөнх	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
8	Т.Мөнгөнцацрал	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
9	Н.Энхцэцэг	ТУЗ-ийн гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
10	Э.Өлзийхутаг	Тооллогын комиссын дарга	☒ ирсэн	☐ ирээгүй
11	Б.Бат-Эрдэнэ	Тооллогын гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
12	Д.Дэлгэрсүрэн	Тооллогын гишүүн	☒ ирсэн	☐ ирээгүй
13	С.Баянцогт	Гүйцэтгэх захирал	☒ ирсэн	☐ ирээгүй

М.Нямдаваа: Хуралдаа оролцож байгаа та бүхэнд баярлалаа. Энэ удаагийн хуралдаан танхим хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа. Танхимын хэлбэрээр зохион байгуулж байгаатай холбоотойгоор хуралдааны зохион байгуулагчаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Буянзаяа ажиллана. Хуралдаан үндсэн дэгийнхээ дагуу явагдана.

Б.Буянзаяа: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хуралдаанд 94,27 хувийн хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн Сандагийн Балжинням 2026 оны 03 сарын 21-ний өдрийн 26/037 тоот итгэмжлэлээр оролцож байна. Ингээд хуралдааны ирц хуульд заасан шаардлагыг хангаж байгаа тул хуралдааныг нээж байна.

Тооллогын комиссын дарга Э.Өлзийхутаг: Алтайн Зам ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралдаанд 51050 ширхэг хувьцаа эзэмшигч Ньюпрогресс Групп ХХК-ийг итгэмжлэлээр төлөөлөн С.Балжинням оролцохоор бүртгүүлсэн байна. Өөр хувьцаа эзэмшигч хуралдаанд оролцохоор бүртгүүлээгүй бөгөөд урьдчилан санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч байхгүй болох агуулга бүхий АЗТК2026001 тоот тооллогын комиссын тогтоол танилцуулав.

	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Ньюпрогресс Групп ХХК-ийг төлөөлөн С.Балжинням	51050 ширхэг	94,27%
	Нийт	51050 ширхэг	94,27%

Б.Буянзаяа: Та бүхэнд тогтоолуудын төслийг танилцуулсан байгаа. Та файлаар давхар татаж авч танилцаж болно. Түүнчлэн бичгэн хэлбэрээр асуулга асуух болон санал өгөх боломжтой. Бид хуралдааны дараа та бүхнээр баталгаажуулж гарын үсэг зуруулна.